

АРИГ БАНК

2020

ЖИЛИЙН ТАЙЛАН

БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Ариг банк нь Эрэлбанк нэртэйгээр 1997 онд Монгол улсын ууган арилжааны банкуудын нэг болон байгуулагдсан. Бид санхүүгийн бүх төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчиддаа санал болгон үйл ажиллагаагаа тогтвортой явуулж байна.

Аригчууд бидний философи маш энгийн. “Өөрийг чинь халамжилж байгаа хүмүүсийг халамжил”. Тэгвэл биднийг болон ер нь бизнесүүдийг хэн халамжилж, “авч явдаг” юм бэ? Гэрэл, дулаантай албан тасалгаанд суух боломжийг хэн өгч байгаа вэ? Бидний цалинг хэн санхүүжүүлж байгаа вэ? Харилцагчид! Хэрэв та манай харилцагч бол, та бас...

ЭРХЭМ ЗОРИЛГО

Ухаан, Хүсэл Уран сэтгэмж Улам шинэлэг хамт олноороо Уулзсан бүхний сэтгэлийг хөдөлгөх банк

ХЭТИЙН ЗОРИЛТ

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний цахим болон биет сувгийн оновчтой хослолоор харилцагчиддаа бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэдэг, харилцагчийн гайхалтай үйлчилгээтэй, нийгмийн хариуцлагаараа манлайлагч банк болох.

АРИГ БАНКНЫ НЭР, ЛОГОНЫ ТАЙЛАЛ

АРИГ БАНК

"АРИГ" хэмээх үг нь:

1. Цэвэр тунгалаг
- Жишээ: Халх нутгийн ариухан агаар ариг ус урсана. /Д. Цэдэв./
2. Арви гам /Монгол Хэлний Хуучин Үгийн Толь/

"Уран Сэтгэмж гэдэг нь ердөө байсан зүйлсийг хооронд нь холбож ашиглан шинэ зүйл бүтээхийг хэлнэ" Стийв Жобс.

Бид өөрсдийн 4 үнэт зүйлсийг холбон харж, бүтээлчээр хөдөлмөрлөснөөр "Уран Сэтгэмж" – ийг бадамлуулахыг илэрхийлсэн. Мөн 4 үнэт зүйлсийг холбож, Ариг гэдэг үгний "А" үсгээр логогоо бүтээсэн билээ.

Цэвэр, Тунгалаг

Ариг гэдэг үгний "Цэвэр, Тунгалаг" гэсэн утгыг график дизайны "transparent technique" буюу "тунгалаг арга"-ыг ашиглан логондоо тусгалаа. "Тунгалаг арга"-ын онцлог тал нь бол хэрэглэгдэж байгаа бүхий л өнгө, дүрс, элементууд нэвт харагддаг, тунгалаг байдагт оршино.

Энэ шинж нь Ариг Банкны логон дээр, өнгөнүүд огтлолцоход аль нэгэн өнгө нөгөөгөө дарж халхлалгүй, бүгд нэвт харагдан шинэ өнгийг үүсгэж байгаа нь юм. Өөрсдийн үзэл бодол, үйл ажиллагаа, байгууллагын засаглалын ил тод байдлыг үүгээр дүрсэллээ.

БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

ХҮМҮҮС

Сэтгэлтэй, Мэдрэмжтэй, Эрч Хүчтэй

Бүх зүйл хүмүүсээс үүдэлтэй. Баг, хамт олон, бизнес, үйлчилгээний байгууллагын аль нь ч сэтгэлтэй, мэдрэмжтэй, эрч хүчтэй хүмүүсгүйгээр оршин тогтнох боломжгүй.
Тиймээс Хүмүүс бусад зүйлсийг бий болгон, нийцүүлэн зангидаж, гол Цөм нь болж байгаа юм. Манай хамт олон төрөл бүрийн мэргэжил, нас, хүйс, ажил амьдралын туршлага, үндэстний төлөөллөөс бүрддэгээр нь бахархаж бид Хүмүүсээ олон төрлийн өнгө, хэмжээ, дүрсээр билэгдлээ.

БҮТЭЭГДЭХҮҮН

Алдуулан бодсон, Амьдралаас үүдсэн

Тулгуур хоёр баганын баруун багана болох "Бүтээгдэхүүн" нь бидний үйлчилгээ хүний хэрэгцээг амдуулан бодсон, асуудлыг шийдсэн, бодит амьдралаас үүдсэн байхыг илэрхийлж халуун дулаан, холоос ялгаран танигдах, эрч хүчээр дүүрэн галын Улаан өнгөөр бүтээсэн билээ.

ҮЙЛ ЯВЦ

Шуурхай, Найдвартай, Саадгүй

Хоёр тийш жийн бат зогсох тулгуур хоёр баганын зүүн багана болох Үйл Явц нь бүтээгдэхүүн үйлчилгээг хэрхэн судлан бүтээж, эцсийн харилцагчид хэрхэн толилуулж, хүргэхийг хэлж байгаа юм. Харилцагчийн нүдээр харахад зарим зүйлсийг бид явцын дунд хичнээн төвөгтэй болгож хувиргасныгаа тэр болгон ухаардаггүй. Тэгвэл бид Үйл Явцаа ямарваа нэгэн саад төвөггүй, ногоон гэрлээр урсгаж байхыг илэрхийлж Ногоон өнгөөр бүтээлээ.

ОРЧИН

Зөчлөлтгөй, Тухтай, Халамжтай

Манайхаар орсон хүн зочломтгой, тухтай, халамжтай орчныг мэдрэх учиртайг Хөх Ягаан өнгөөр төлөөлүүллээ. Хөх Ягаан өнгө нь "орчин үе"-ийг илэрхийлдэг өнгө юм.

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭНДЧИЛГЭЭ

ЭРХЭМ ХҮНДЭТ ХАРИЛЦАГЧИД, ТҮНШЛЭГЧИД, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД БОЛОН БАНКНЫ АЖИЛЛАГСАД АА,

Та бүхэндээ 2020 оны ажлын гүйцэтгэлийг танилцуулж байна.

2020 онд дэлхий нийтээр Ковид цар тахлын улмаас эдийн засаг агшиж, бизнес эрхлэгч нарт хүндхэн жил болсон ч Ариг банк эрсдэлийг даван туулах төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлж, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах, хувь нийлүүлсэн хөрөнгийг 50 тэрбум төгрөгт хүргэх шаардлагыг биелүүлснээр банкныхаа эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, компанийн засаглалыг сайжруулахад илүү анхаарч, төвлөрсөн жил боллоо.

Ариг Банкны түүхэн замналын 22 гаруй жилийн турш бид харилцагч нараа дээдэлж ирсэн бөгөөд бидний өмнө тулгарч буй шинэ сорилт бүрээс суралцан, банкны үйл ажиллагаанд гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлыг дахин давтагдахгүй байхад болон компанийн зохистой засаглалыг сайжруулахад банкны Төлөөлөн удирдах зөвлөл болон Хувьцаа эзэмшигчдийн дэмжлэг, сэтгэл зүтгэл нэн шаардлагатай байгаад анхаарал хандуулсан жил байлаа.

Банкныхаа дүрмийн санг 50 тэрбум төгрөгт хүргэж, өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцааг 35,4%-иар хангаж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг 63,4%-иар ханган биелүүлснээр бид харилцагч нарынхаа өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, банкныхаа нэр хүндийг бататгаж чадлаа. Харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээ шаардлагыг ойлгох улмаар санхүүгийн хувьд бэхжих нөхцөл бололцоог хангахын тулд өөрчлөн шинэчлэлтийг цаг алдалгүй хийх нь дамжиггүй бөгөөд цаашид ч илүү ихийг хийж бүтээнэ гэдэгт Аригчууд бид санал нэг байдаг.

2020 онд бидэнтэй хамт байсан харилцагчид, түнш байгууллагууд, хувьцаа эзэмшигчид болон цар тахлын хүнд үед ажилласан хамтран ажиллагсад нартаа хандан бидэнд итгэл хүлээлгэн дэмжин ажилласан та бүхэндээ Ариг банкны удирдлагын багийн өмнөөс талархаж буйгаа илэрхийлж байна. Цаашид бид хэрэглэгчдийн хүсэлд нийцсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлэн хүргэж, компанийн сайн засаглалыг хэрэгжүүлэхийн төлөө хичээнгүйлэн ажиллах болно.

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

Б.Ариунжаргал

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

60.46%

ДЭМ САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХХК

Ариг Банк ХХК-ийн толгой компани бөгөөд банк, санхүүгийн салбарт голлон төвлөрч ажилладаг. Ариг банкны энгийн хувьцааны 60.46 хувийг эзэмшигч компани юм. Тус компанийн 100%-ийн хувьцааг иргэн Б.Эрдэнэбат эзэмшдэг.



39.54%

УЛААНБААТАР ИМПЕКС ХХК

Ариг Банк ХХК-ийн толгой компани ба банк, санхүүгийн салбарт хөрөнгө оруулахад төвлөрч ажиллаж байна. Ариг банкны энгийн хувьцааны 57.68 хувийг эзэмшигч компани юм. Тус компанийн 73.18 хувийг иргэн Ш.Баярсайхан, 39.54 хувийг "Номин реалтор" ХХК эзэмшдэг.

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Пүрэвийн МӨНХ-ЭРДЭНЭ

ТУЗ-ийн дарга, хараат бус гишүүн

Санжаагийн САЙНБАТ

ТУЗ-ийн гишүүн

Шагдарсүрэнгийн БАЯРСАЙХАН

ТУЗ-ийн гишүүн

Сэнгэдоржийн ХОСБАЯР

ТУЗ-ийн гишүүн

Дэлэгийн ТҮВШИНТАМИР

ТУЗ-ийн хараат бус гишүүн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Ариг Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/ нь “Банкны тухай хууль”, “Компанийн тухай хууль”, “Ариг Банкны дүрэм” болон “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон журам тогтоомж, дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай биелүүлж ажиллахыг чиглэлээ болгодог.

ТУЗ-ийн үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх, үүрэг зэрэг нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулагдах бөгөөд хуульд заасны дагуу ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн Дарга зарлаж хуралдуулна. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хэрхэн шийдвэрлэсэн тухай тэмдэглэлийг хөтлөн, гарын үсгээр баталгаажуулж хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигч нар болон Монголбанкинд хүргүүлэн ажилладаг.

Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл зэрэгт холбогдох хороод нь эрх, үүргийн дагуу хяналт тавин ажилладаг болно.

ТУЗ нь банкны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахаар зохион байгуулагдсан бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх эрхийг банкны Хувьцаа эзэмшигч нар эдэлнэ /Хараат бус гишүүнийг Монголбанкны зөвшөөрснөөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ/

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРОО

Банкны зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр хүндийн, мэдээлэл технологийн болон бусад төрлийн эрсдэлийн удирдлагын талаар авч буй арга хэмжээ нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавин ажиллах үүрэгтэй бөгөөд журмын хэрэгжилтийг жил болгон хянаж, ТУЗ-д зохистой өөрчлөлт оруулах талаар санал гарган ажиллана.

АУДИТЫН ХОРОО

Банкны санхүүгийн үнэн зөв, бүрэн бүтэн тайлагнал, банканд хийгдэх дотоод болон хөндлөнгийн аудитаар ажиллах аудиторуудын үйл ажиллагааг хянах, ТУЗ болон Хувьцаа эзэмшигчид нэрсийг санал болгох, сонгон шалгаруулах, цалин урамшуулал олгох, ажлаас чөлөөлөх, аудитын хүрээ, давтамжийг тогтоох, тайлантай танилцах, аудитын дүгнэлтэд дурдсан банкны дотоод хяналтын тогтолцооны сул талууд, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг Гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомжийн дагуу тохиромжтой цаг хугацаанд хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавин ажиллах үүрэгтэй.

ХҮНИЙ НӨӨЦ, ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, банканд үр ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд банкны цалин урамшууллын бодлого, практикт нь чадварлаг ажилтан, менежерийг ажилд авах, улмаар тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулан хөгжүүлэх замаар банкны бизнесийн зорилтдоо хүрэх, тогтвортой бизнесийн хөгжил авчрахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

АУДИТЫН ГАЗАР

Банкны тоон болон чанарын үзүүлэлтүүд дээр үндэслэн одоо байгаа болон цаашид үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн төвшин тогтоох, эрсдэлтэй цэг болон газар дээрх шалгалтын хэрэгцээг тодорхойлж ажиллана. Банкны үйл ажиллагаанд газар дээр нь хийх шалгалтын төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан, үр дүнг ТУЗ-д танилцуулан, шаардлагатай арга хэмжээг авч, зөвлөмжийг өгч ажиллана.

УДИРДЛАГЫН БАГ

Балдандоржийн АРИУНЖАРГАЛ

Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч

Бат-Очирын БЯМБАНОРОВ

Дэд захирал

Цэндийн ДАМДИНСҮРЭН

Дотоод хяналтын газрын захирал

Жамъянгийн НАРАНЦЭЦЭГ

Үйл ажиллагааны газрын захирал

Нанзадбаярын ОРХОН

Хүний нөөцийн газрын захирал

Батсайханы ОЮУНЦЭЦЭГ

Салбарын удирдлагын газрын захирал

Баянжаргалын БАТ-ЭРДЭНЭ

Мэдээлэл технологийн газрын захирал

Бадамааараагийн АЛТАНСҮХ

Бизнес удирдлагын газрын захирал

Даржаагийн ОДОН

Тогтвортой хөгжлийн газрын захирал

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХҮЛЭГТ ХЭННУ АУДИТ

АРИГ БАНК

Лавлах тоо: Б-215

Огноо: 2021.04.09

Хуулбар:

"АРИГ БАНК" ХХК

Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл

"Ариг банк" ХХК (цаашид "Банк" гэх)-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Балдандорж овогтой Арнуунжаргал, банкны Үйл ажиллагааны газрын захирал Жамьян овогтой Наранцэцэг, бид энэхүү тайлангийн 1-эхс, 56 дугаар хуудсанд толилуулсан тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлсэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн багц заавар, журмын дагуу бэлтгэсэн богино 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал, үр дүн өдөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үгүйсгэж мэдэгдэж байна.

БАРИУНЖАРГАЛ
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭГЧ ЭРХ

ЖАНАРАНЦЭЦЭГ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ЗАХИРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2021 оны 04 дүгээр сарын 08

Чингэлтэй Дүүрэг Чингэлтэй
Хан-Уул дүүрэг
Улаанбаатар хот 17061
Монгол Улс

Байгуулагын цахим
хуяг: info@arigbank.mn
Вэб: www.arigbank.mn

Лавлах утас
7013 3060

АРИГ БАНК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Ариг банк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид Ариг банк ХХК (цаашид "банк" гэх)-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, түүнийг өдөөр тасалбар болгосон орлогын далгаранхуй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар "Ариг Банк" ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх банкны санхүүгийн байдал болон үр өдөөр дүүгэвэр болгосон жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлсэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн багц заавар, журмын дагуу бүтээгдсэн гэдэг утгаар зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид "АОУС" гэх)-ын дагуу гүйцэтгэсэн болно. Үг стандартын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс батлагдсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид "МНБЕЗ-н дүрэм" гэх)-ийн дагуу компаниас хараат бусаар аудитаа хийж гүйцэтгэсэн ба МНБЕЗ-н дүрмийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний үзэж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Асуудлыг онцгойлсон зүйл[1]

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх тасалбар болгосон санхүүгийн тайлангийн өдөр ба аудиторын тайлангийн өдрийн хооронд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны тушаалаар тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбумд хүрэх шаардлагыг биелүүлж, хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэн тул Монголбанкнаас Ариг банкнд авч хэрэгжүүлсэн нөхцөлт удирдлагын арга хэмжээг дүгнэвэр болгон гүйцэтгэх удирдлагыг томилсон байна. Далгаранхуй мэдээллийг тодруулгын 33 дахь хэсэгт тусгасан болно.

Санхүүгийн тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг

Удирдлага нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлсэн Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн багц заавар, журмын дагуу бэлтгэн, шударгаар илэрхийлэх, алдаагүй санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай залуу үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийг тасан бууллах, үйл ажиллагаг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд Удирдлага компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Засаглах эрх бүхий этгээд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

[1] АОУС 706 Хараат бус аудиторын тайлангийн асуудлыг онцгойлсон хэсэг ба бусад зүйлсийн хэсэг

Хүлэгтхүннү аудит" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сити тауэр, 1001 тоот
Утас/Факс: +(976)-7014 0505

Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг

Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл санаатай залуу үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бид аливаа бусад этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдаат илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай залуу үйлдлээс үүсч болох ба данганаараа эсвэл нийтдээ эдгээр санхүүгийн тайланд үндэслэсэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн ул итгэх үзэлийг баримтлан ажилладаг. Үүнээс гадна:

- Залиа мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн, уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залиа мэхнээс үүссэн материаллаг алдаат илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдаат илрүүлэхгүй байх эрсдэлээс хярыцангуй их байдаг. Учир нь залиа мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг ул ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоон дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөлөлд суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах, эсвэл хийсэн тодруулга нь хангалттай байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтэз өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхэз зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайланд нь үнэн зөв толилуултын шаардлагыг хангахүйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитыхнаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Батлагдсан.

И. Чулуунчаа
Гүйцэтгэх захирал
Хүлэгтхүннү Аудит ХХК

2021 оны 04 дугаар сарын 08-ны өдөр
Монгол Улс, Улаанбаатар хот

Хүлэгтхүннү аудит" ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сити тауэр, 1001 тоот
Утас/Факс: +(976)-7014 0505

АРИГ БАНК

"АРИГ БАНК" ХХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тодруулгын дугаар	2020 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	20,280,174	26,847,267
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	6	2,781,844	11,497,494
Хөрөнгөө оруулалт	7	3,623,144	3,177,744
Хэрэглэгчид олгосон зээл ба урьдчилгаа (цэвэр дүнгээр)	8	24,004,468	54,613,114
Бусад санхүүгийн хөрөнгө	9	224,424	282,869
Бусад санхүүгийн бус хөрөнгө	10	5,620,494	1,951,155
Борлуулах зориулалттай хөрөнгө	11	588,608	1,904,804
Үндсэн хөрөнгө	12	2,905,664	4,385,409
Биет бус хөрөнгө	13	602,298	771,200
Нийт хөрөнгийн дүн		**60,631,118**	**105,431,055**
Өр төлбөр			
Харилцах	14	1,403,876	2,305,789
Хадгаламж	14	27,956,678	62,209,016
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	15	4,719,011	5,647,081
Бусад эх үүсвэр	15	1,906,597	1,894,307
Бусад санхүүгийн өр төлбөр	16	324,725	749,736
Бусад санхүүгийн бус өр төлбөр	16	39,699	266,722
Нийт өр төлбөрийн дүн		**36,350,586**	**73,072,651**
Өөрийн хөрөнгө			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	17	35,009,500	35,009,500
Дахин үнэлгээний нэмэгдэл		195,893	195,893
Хуримтлагдсан ашиг, алдагдал		(10,927,902)	(2,850,030)
Бусад өөрийн хөрөнгө		3,041	3,041
Өөрийн хөрөнгийн дүн		**24,280,532**	**32,358,404**
Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн дүн		**60,631,118**	**105,431,055**

"АРИГ БАНК" ХХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Тодруулгын дугаар	2020 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
Хүүгийн орлого	18	**7,278,868**	**18,754,888**
Монголбанканд байршуулсан хөрөнгийн		186,974	392,425
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн		1,522	5,091
Үнэт цаасны		1,287,607	2,358,136
Зээлийн		5,802,764	15,999,235
Хүүгийн зардал	19	**4,302,515**	**9,627,824**
Харилцахад төлсөн хүү		4,947	30,402
Хадгаламжид төлсөн хүү		4,007,889	9,101,185
Зээлийн хүүгийн зардал		181,164	414,750
Бусад хүүгийн зардал		108,515	81,487
Хүүгийн цэвэр орлого		**2,976,353**	**9,127,064**
Эрсдэлийн сангийн зардал	20	**9,626,700**	**7,740,900**
Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого		**(6,650,347)**	**1,386,164**
Хүүгийн бус орлого		**119,583,929**	**38,417,074**
Арилжааны орлого	21	382,670	389,504
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого	22	118,768,593	37,255,250
Банкны бүтээгдэхүүнтэй холбоотой үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	23	349,011	695,234
Бусад хүүгийн бус орлого		83,655	77,086
Бусад орлого, олз	25	3,440,025	1,463,048
Хүүгийн бус зардал		**125,392,282**	**47,285,269**
Бусад эрсдэлийн сангийн зардал	20	933,390	3,394,986
Арилжааны зардал	21	166,719	83,165
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зардал	22	118,647,296	37,221,654
Хураамж, шимтгэлийн зардал	23	207,502	287,239
Үйл ажиллагааны бусад зардал	24	5,437,377	6,298,226
Бусад зардал, гарз	26	21,644	226,577
Татварын өмнөх ашиг, алдагдал		**(9,040,319)**	**(6,245,560)**
Орлогын татварын зардал	27	(913,957)	(604,282)
Татварын дараах ашиг, алдагдал		**(8,126,362)**	**(5,641,278)**
Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал			-
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал		**(8,126,362)**	**(5,641,278)**
Бусад дэлгэрэнгүй орлого			-
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн		**(8,126,362)**	**(5,641,278)**

АРИГ БАНК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"АРИГ БАНК" ХХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**35,009,500**	**195,893**	**3,041**	**2,839,923**	**38,048,357**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алданы залруулга	-	-	-	(48,674)	(48,674)
Залруулсан үлдэгдэл	35,009,500	195,893	3,041	2,791,248	37,999,683
Тайлант үеийн ашиг (алдагдал)	-	-	-	(5,641,278)	(5,641,278)
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**35,009,500**	**195,893**	**3,041**	**(2,850,030)**	**32,358,405**
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алданы залруулга				48,489	48,489
Залруулсан үлдэгдэл	35,009,500	195,893	3,041	**(2,801,541)**	**32,406,893**
Тайлант үеийн ашиг (алдагдал)				(8,126,362)	(8,126,362)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**35,009,500**	**195,893**	**3,041**	**(10,927,903)**	**24,280,532**

"АРИГ БАНК" ХХК-ийн 2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2020 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	**(9,040,319)**	**(6,245,560)**
Орлого, зардлын тохируулга:	**10,768,018**	**2,773,551**
Эрсдэлийн сангийн зардал	10,560,090	11,135,886
Элэгдэл, хорогдлын зардал	875,545	755,628
Хуримтлуулсан хүүгийн (орлого)	(7,278,868)	(18,754,888)
Хуримтлуулсан хүүгийн зардал	4,302,515	9,627,824
Хөрөнгө дээнээс хассаны гарз (олз)	7,004	9,101
Бусад олз, гарз	2,301,732	-
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн тохируулга:	**(8,754,060)**	**(12,940,750)**
Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгийн бууралт (өсөлт)	8,715,649	(2,015,145)
Арилжааны үнэт цаасны бууралт (өсөлт)	-	2,000,000
Зээлийн бууралт (өсөлт)	21,226,470	20,951,650
Бусад санхүүгийн хөрөнгийн бууралт (өсөлт)	58,445	181,389
Бусад санхүүгийн бус хөрөнгийн бууралт (өсөлт)	(3,669,339)	(2,592,212)
Харилцах, хадгаламжийн өсөлт (бууралт)	(33,510,318)	(27,454,049)
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрийн өсөлт (бууралт)	(922,933)	(4,568,122)
Бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт (бууралт)	(425,011)	439,296
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн өсөлт (бууралт)	(227,023)	116,443
Бусад тохируулга:	**1,386,807**	**7,512,419**
Авсан хүү	8,012,514	18,287,743
Төлсөн хүү	(5,949,911)	(10,775,324)
Эрсдэлийн сангаас хасасан зээл, авлага	(675,796)	
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(5,639,554)**	**(8,900,339)**
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Хугацааны эцэс хүртэл эзэмшиж үнэт цаас борлуулсны орлого	-	1,081,800
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(87,620)	(447,475)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(3,678)	(160,077)
Борлуулахад бэлэн үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	-	(5)
Хугацааны эцэс хүртэл эзэмшиж үнэт цаас олж эзэмшихэд төлсөн	(445,400)	(656,900)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(536,698)**	**(202,657)**
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бусад эх үүсвэрт төлсөн	(375,400)	(659,727)
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	(113,436)	-
Бусад	(23,302)	
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(512,138)**	**(659,727)**
Валютын ханшийн зөрүү	121,298	(33,596)
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	**(6,567,093)**	**(9,796,319)**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	**26,847,267**	**36,643,585**
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**20,280,174**	**26,847,267**

АРИГ БАНК

2020.12.31-НИЙ БАЙДЛААРХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ



ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА

АРИГ БАНК

2020.12.31-НИЙ БАЙДЛААРХ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

НИЙТ ХӨРӨНГӨ

	(тэрбум төгрөг)
2020	60.6
2019	105.4
2018	144.4

ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ

	(тэрбум төгрөг)
2020	42.8
2019	64.1
2018	85.0

ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ

	(тэрбум төгрөг)
2020	28
2019	61.5
2018	88.9

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

	(тэрбум төгрөг)
2020	24.3
2019	32.4
2018	38.1

НИЙТ ОРЛОГО

	(тэрбум төгрөг)
2020	11.5
2019	21.3
2018	19.1

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

	(тэрбум төгрөг)
2020	5.4
2019	6.3
2018	6.2

АРИГ БАНК

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Аригийн нийгэмд үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэх нь

Урт хугацааны тогтвортой хөгжил, түүний дотор тогтвортой санхүүжилтийн зарчмыг дэлгэрүүлэх нь манай харилцагчдын үндсэн хэрэгцээ шаардлагад нийцэж буйгаас гадна манай банкны өөрийн амжилтын эх үндэс мөн гэдгийг бид хүлээн зөвшөөрч аль болох олон иргэдэд хүрч ажиллахыг эрмэлздэг. Монгол улсын Тогтвортой санхүүжилтийн Бодлогын Санамж Бичигт гарын үсэг зурж энэ хөтөлбөрт Ариг Банк 2013 онд нэгдэн орсноос хойш өөрийн Банкны бодлого журамд тогтвортой санхүүжилтийн зарчмуудыг суулган өгч, үйл ажиллагаандаа уг зарчмуудыг нэвтрүүлэн ажиллаж байна. Түүнчлэн өөрийн Компанийн Нийгмийн Хариуцлагын (КНХ) санал санаачлагуудаараа дамжуулан бусдыг үлгэрлэн манлайлж, банкны салбартаа тэргүүлж ажиллахыг эрмэлзэнэ.

ШИЛДЭГ НИЙГМИЙН ХАРИУЦЛАГАТАЙ БАНК

Ариг Банк нь бие даасан судалгаа явуулдаг Хонг Конг-т байрладаг ASIAMONEY сэтгүүлийн "Монгол улсын 2019 оны Компанийн Нийгмийн Хариуцлагын Шилдэг Банк (Best CSR Bank of Mongolia-2019) шагналд гурав дахь жилдээ дахин тодорхойлогдож уг шагналын эзнээр дахин шалгарлаа. Сэтгүүлийн редакц болон бие даасан сэтгүүлч нар Улаанбаатар хотноо хүрэлцэн ирж, цуврал ярилцлагын үр дүнгээр Үнэлгээг хийсэн болно.

"ДЭМ ДЭМЭНДЭЭ" ХАНДИВЫН ХАЙРЦАГ

Ариг Банк нь өөрийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монголын Улаан Загалмай Нийгэмлэгтэй хамтран ажиллах Санамж бичигт 2017 оны 5 сарын 9-нд гарын үсэг зурж, "Хандивын дэлгүүр" олон улсын туршлагыг Монголд нэвтрүүлэх болсон юм.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Харилцагчдын Өргөөдөд байдаг ДЭМ ДЭМЭНДЭЭ хайрцгаар дамжуулан иргэдийн илүүдэл болон хандивлахыг хүсч байгаа хувцас, эд хогшлыг цуглуулан Монголын Улаан Загалмай Нийгэмлэгт хүлээлгэн өгдөг хүмүүнлэгийн үйл ажиллагаагаа 2017 оноос хойш үргэлжлүүлж байна. Иргэдийн хандивласан эд зүйлс, хуучин хувцсыг хүлээн авч, улирал бүр МУЗН-т хүлээлгэн өгч улмаар МУЗН-ийн дэлгүүр, хандивын цэгээр дамжуулан эмзэг бүлгийнхэнд тарааж өгдөг билээ.

ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны (ЕСБХБ/EBRD) ТЭЗҮ боловруулах төсөл:

2020 онд Улаанбаатар хотын захиргаа буюу Нийслэлийн Орон Сууцны Корпорацийн хүсэлтээр орлогод нийцсэн 714 айлын эрчим хүчний хэмнэлттэй ногоон орон сууцны хороолол барих төслийн Техник-Эдийн Засгийн Үндэслэл /ТЭЗҮ/ -ийг боловсруулах төслийн багт Ариг Банк оролцсон болно. Энэхүү ТЭЗҮ боловсруулах төслийн баг нь гадаад дотоодын байгаль орчин, нийгмийн судалгаа, барилгын зураг төсөл зохион бүтээгч, санхүүгийн шинжээч нарын бүрэлдхүүнтэй байлаа. Ариг Банк нь уг төслийн хүрээнд баригдах Ногоон хороололд байр авч буй, эсвэл түрээслэн эзэмших гэрээгээр байранд орж буй зээлдэгч нарын санхүүжилтийн загвар боловсруулах ажилд оролцсон билээ.

НОГООН ОФФИС

Ариг Банкны Байгаль Орчны Бодлогын хүрээнд ISO 14001 олон улсын стандартыг нэвтрүүлснээр, өдөр тутмын дотоод үйл ажиллагаандаа байгаль орчинд ээлтэй дадал заншил хэвшүүлэх, эрчим хүч ба ус, цаасны хэрэглээгээ бууруулах зорилтоо амжилттай хэрэгжүүлж байна. Тухайлбал, Ариг Банкны дээвэр дээр байрлуулсан Нарны эрчим хүч үүсгүүр нь 2015 оны 6 сараас хойш 2020 оны 12 сарын 31-ний байдлаар өөрийн үйлдвэрлэсэн эрчим хүчний үйлдвэрлэлээр нийт 42.6 тонн CO_2 ялагруулалтыг бууруулж чадсан байна. Энэ бол уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг бууруулахад оруулж буй Аригчуудын бага ч болов хувь нэмэр билээ.

Ариг Банк нь өөрийн ногоон оффисын туршлагыг дэлгэрүүлэх зорилгоор "Ариг Тур" /Arig Tour/-ыг зохион байгуулдаг уламжлалтай бөгөөд зөвхөн 2019 онд 8 удаагийн тур зохион байгуулж нийт 153 гадаад дотоодын зочид хамруулжээ.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

2018 онд батлагдсан Ариг Банкны "Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах журам"-ын дагуу цаас, шил, хуванцар ба ахуйн хог хэмээн 4 ангилж, ЭМНБХ ба Хан Уул дүүрэгтэй хамтран дахин боловсруулах хогийг "Мог Пластик" үйлдвэрт тогтмол нийлүүлэн ажиллаж байна.

ХАРИЛЦАГЧИЙН ӨМНӨ ХҮЛЭЭСЭН ҮҮРЭГ

Харилцагчдаас ирсэн саналыг 24/7 цагаар ажилладаг Лавлах төв (70133060) болон бусад 17 сувгаар хүлээн авч байгаа бөгөөд энэ чиглэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулах замаар харилцагчийн эрх ашгийг хамгаалах, шийдвэрлүүлэх шаардлагатай саналуудыг холбогдох газар, хэлтэст дамжуулан ажиллаж байна.

Өмнөх онтой харьцуулахад харилцагчийн санал, хүсэлтийн тоо 77%-аар, гомдол 60%-аар тус,тус буурсан нь COVID-19 тахлаас шалтгаалан улсын хэмжээнд үйл ажиллагааны хоригууд хэрэгжиж байсантай холбоотой гэж үзэж байна.

ISO 10002 стандартад нийцүүлэн Лавлах төвийн үйл ажиллагааг зохион байгуулж, харилцагчийн өмнө хүлээсэн үүргийн дагуу харилцагчид үнэн зөв, мэдээллийг түргэн шуурхай дамжуулан, нуцлалыг ханган ажилласан бөгөөд харилцагчийн сэтгэл ханамжийн үнэлгээ 86%-тай байна.

86%
сэтгэл ханамж

24 7013 3060

www.arigbank.mn | Arig Bank | Arig Bank | arig.bank (#arigbank) | Arig Bank (@ArigBankMN)

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Эрсдэлийн удирдлагын бүтэц нь 4 түвшинд хуваагдана.

I ТҮВШИН

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Эрсдэлийн Удирдлагын Хороо /ТУЗ-н ЭУХ/: Эрсдэлийн удирдлагын баримтлах стратеги, бодлого болон банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинг батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах

II ТҮВШИН

Банкны Эрсдэлийн Хороо /ЭХ/ нь банкны эрсдэлийн бодлого, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэмжээ нь банкны үндсэн үйл ажиллагаатай нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, түүний хэрэгжилтийг ТУЗ-ийн ЭУХ-д тайлагнах банкны гол эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг авах, эрсдэлийн удирдлагатай холбоотой журам зааврыг батлах, эрсдэлийн соёлыг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэгжилтийг хянах үйл ажиллагааг хамаарна.

III ТҮВШИН

Эрсдэл хариуцсан нэгжүүд: Эрсдэлийн алба, Зээлийн эрсдэлийн хэлтэс, Санхүүгийн удирдлагын хэлтэс, Дотоод хяналтын газар. Эрсдэл хариуцсан нэгжүүд нь эрсдэлийн бодлого ба журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, мөн банкны үйл ажиллагааг дэмжих болон удирдах нэгжүүд, бизнес нэгжүүдийн эрсдэлийн удирдлагад дэмжлэг үзүүлэх, эрсдэлийн удирдлагад оролцогчдыг холбох, эрсдэлийн нэгдсэн мэдээллээр хангах, банкны эрсдэлийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулах ажиллагааг хариуцна.

IV ТҮВШИН

Салбарын нэгж, өргөөд нь өөрсдийн хариуцан ажиллаж буй үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийг удирдаж ажиллана.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд дараах эрсдэлээс сэргийлж ажиллана. Үүнд:

- Ашиглан,
- Залилан,
- Ажлын байрны аюулгүй байдлын эрсдэл,
- Харилцагчийн эрсдэл,
- Бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл,
- Мэдээлэл технологийн системийн эрсдэл,
- Дотоод үйл явцын эрсдэл,
- Гадаад хүчин зүйлийн эрсдэл,
- Хуулийн болон гадны зохицуулалтад үл нийцэх эрсдэл,
- Хариуцлагын эрсдэл,
- Хөрөнгийн эрсдэл,
- Боловсон хүчний эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь банкны үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг тодорхойлох, эрсдэлийг үүсгэж буй хүчин зүйлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга замын талаар шийдвэрүүдийг гаргаж гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж ажилладаг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлийн үндсэн гурван чиглэлд тулгуурлан эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэгдэж байна. Өнгөрөгч онд банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, хяналтын тогтолцооны оновчтой байдлыг үнэлэн, зөвлөмж боловсруулан холбогдох газар нэгжид хүргүүлэх замаар үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан.

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2020 онд гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлж, банкны мэдээллийн болон бүртгэлийн системд хандах хэрэглэгчийн эрхийн зохицуулалтыг шинэчлэн боловсруулж, хэрэглэгчийн зүй бус хандалт, хэрэглээнээс үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж хүлээн зөвшөөрөх хамгийн бага түвшинд барьж ажиллалаа.

Мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд бодлого журмыг шинэчлэн баталж мэдээллийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.

ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2020 онд Монголбанкнаас шинэчлэн баталсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам"-тай холбогдуулан дотоод дүрэм, журамд шинэчлэлт хийж, үлдэгдэлтэй зээлийн ангиллыг өөрчилж, эрсдэлийн сан байгуулан Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажилласан.

2020 онд Ариг Банк нь зээлийн эрсдэлийн бодлогоо нарийвчлан тодорхойлж, эдийн засгийн нөхцөл байдал, банкны богино болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөтэй уялдуулан, зээлийн эрсдэлийн хязгааруудыг шинэчлэн өөрчилж, зээлийн эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг урьдчилан оновчтой хэрэгжүүлсэн. Банкны зээлийн эрсдэлийн удирдлагын гол зорилго нь гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр зээлийн багцын чанар муудах мөн эдийн засгийн салбар, валют, зээлийн нэг бүтээгдэхүүнд эсвэл холбоотой бүлэг этгээдэд зээлийн хэт төвлөрөл бий болгохоос урьдчилан сэргийлэх, түүнчлэн банк эрх бүхий байгууллага болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд оршино.

Энэхүү зорилгын хүрээнд бид зээлийн багцын чанарт үнэлгээ хийх, хүлээгдэж буй алдагдлын хэмжээг тодорхойлох, төвлөрлийн эрсдэлийг үнэлэх, хязгаарлах,нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр зээлийн багцын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна. Ариг Банк нь үр ашигтай эрсдэлийн удирдлагын гол үзүүлэлт болох эрсдэлийн хязгаарлалтуудыг банкны хэмжээнд, холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээг тооцоолон зохистой хэмжээнд боловсруулан баталж, хэрэгжүүлж ажилладаг. Ариг Банкны үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр зээлийг тухайн өдөрт нь бус цаг, минутын дотор шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлага нэмэгдсээр байна. Мөн зээлийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх үүднээс банкны салбар,тооцооны төвүүд, Зээлийн Хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөл зэрэг зээл шийдвэрлэх түвшин болгонд зээлийн дээд хэмжээг тодорхойлж, зээлдэгчийн зээлжих чадварыг кредит скорингийн системээр үнэлэн ажиллаж байна.

ТЕХНОЛОГИЙН ИННОВАЦИ

Манай банк нь хэрэглэгчдийнхээ тав тухтай, бүтээмж өндөртэй, аюулгүй байдлыг тэргүүн эгнээнд тавин ажилладаг билээ. Энэхүү зорилгын хүрээнд бид бүтээгдэхүүн, үйлчилгээгээ олон сувгаар, цаг хэмнэн хүргэх үүднээс дижитал технологийг ашиглан SWIPE карт уншигч, PocketBank гар утасны аппликейшн, интернет банк, хуруугны судасны байрлалаар таних шинэ технологи iDual, автомат бэлэн мөнгөний машин TCR зэргийг нэвтрүүлээд багагүй хугацаа өнгөрсөн байна.

Орчин үеийн технологийн чиг хандлагыг шингээсэн бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчиддаа үзүүлэх чиглэлээр дараах ажлуудыг нэвтрүүлээд байна.

- Банкны үйл ажиллагааны тасралтгүй байдлыг 99.99%-тай барьж ажилласан. Ингэснээр харилцагчид хүрч буй бүтээгдэхүүн үйлчилгээ нь тасалдалгүй, найдвартай ажиллаж байна.
- Хадгаламж барьцаалсан зээл цахимаар олгодог болсон.
- Зээлийн төлбөр хойшлуулах хүсэлтийг цахимаар авч шийдвэрлэн ажилласан.

ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Ковид цар тахалтай холбоотойгоор зайнаас, цахимаар ажиллах туршлагыг хуримтлуулж эрсдэлгүй ажиллах нөхцөлөөр хангасан бөгөөд хэдийгээр эдийн засгийн хувьд хэцүү нөхцөлд байсан ч өнгөрсөн хугацаанд орон тооны цомхотгол хийлгүй, ажилтнуудын цалин хөлсийг 100% олгож ажилласан.

Цар тахлаас болж тодорхой сургалт хөгжүүлэлтийн арга хэмжээнүүд бүрэн хийгдэх боломжгүй байсан ч тайланд хугацаанд нийт давхардсан тоогоор 230 гаруй ажилтныг сургалтанд хамруулсан.



|давхардсан тоогоор|
230 ажилтан сургалтанд хамрагдсан

2020

Банканд тайлант хугацаанд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын үеийн осол гэмтэл бүртгэгдээгүй.

АЖИЛЛАСАН ЖИЛИЙН ДУНДАЖ 4.5 ЖИЛ | ДУНДАЖ НАС 35

БИД БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛАН ХАРИЛЦАГЧИДДАА ДЭВШИЛТЭТ ЦАХИМ ШИЙДЛҮҮДИЙГ ХҮРГЭСЭЭР БАЙНА

Дэвшилтэт технологид тулгуурлан Ариг Банк нь харилцагчидийнхаа хэрэгцээнд нийцүүлэн бүтээгдэхүүн үйлчилгээгээ тасралтгүй сайжруулсаар байна. Бид өөрсдийн үйл ажиллагааны процесс бүрийг автоматжуулах замаар үр бүтээмжийг нэмэгдүүлэх, ашиггүй зардлаа бууруулах үүднээс технологийн шийдлүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн цаашид бид энэ салбарт өрсөлдөх чадамжийн үзүүлэлт нэмэгдүүлэх хүрээнд уламжлалт загваруудтай харьцуулахад хурдан, хялбар болох Финтек (Санхүү + Технологи) буюу санхүүгийн ертөнц дэх технологийн хувьсалд нэгдэн өөрийн үйл ажиллагааны бүтээмж, боломж зэргийг нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.

БИД БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛАН ХАРИЛЦАГЧИДДАА ДЭВШИЛТЭТ ЦАХИМ ШИЙДЛҮҮДИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭН ХҮРГЭСЭЭР БАЙНА

ВИЗА КОНТАКТЛЕСС КАРТ

Ариг Банк нь олон улсын виза /visa/ картаа зайнаас уншуулах дэвшилтэт технологи нэвтрүүлэн, харилцагчдадаа эх орондоо төдийгүй олон улсад төлбөр тооцоогоо илүү хялбараар хийх боломжийг бүрдүүллээ.

Виза контактлесс карт нь зайнаас уншигдах технологи бүхий карт бөгөөд карт уншигч ПОС машин дээр картыг биет холболт үүсгэлгүй зайнаас гүйлгээ хийх боломж олгодгоороо онцлогтой. Харилцагч картаа ийнхүү зайнаас ашигласнаар картаа бусдад дамжуулах шаардлагагүй болж, мэдээллээ алдах эрсдэлээс сэргийлэх, цаг хугацаа хэмнэх давуу талтай болсон юм.

АРИЛЖААНЫ ДАНС НЭЭХ ОНЛАЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Банкны төдийгүй бүхий л үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж буй өнөөгийн нөхцөлд харилцагчдадаа зориулж онлайнаар буюу ariljaa.arigbank.mn цахим сайтаар дамжуулан брокер диллерийн компаниудад хувьцааны данс болон банкны Эскроу дансыг шинээр нээх боломжийг олголоо. Энэхүү үйлчилгээг ашигласнаар харилцагч Эрдэнэс таван толгой ХК-ны 1072 хувьцааны ногдол ашгаа авахаас гадна хөрөнгийн зах зээлд оролцож, нэмж хувьцаа авах замаар компаниудад хөрөнгө оруулалт хийх боломжтой болсон юм. Одоогийн байдлаар Ариг Банк нь Монгол улсын томоохон үнэт цаасны 14 компанитай хамтран ажиллаж харилцагчдынхаа хувьцааны арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

ОНЛАЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ

Ариг банк нь тайлант онд харилцагч нартаа зайнаас банкны үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор Картаар үйлчлэгч байгууллагын онлайн хүсэлтийг хүлээж авах үйлчилгээ, Покет банк үйлчилгээг ашиглан харилцах хадгаламжийн данс нээх, хадгаламжийн хугацаа сунгах, хадгаламж барьцаалсан зээл авах үйлчилгээнүүдийг тус тус шинээр нэвтрүүллээ. Цаашид харилцагчийн хүсэлт шаардлага дээр үндэслэн хэрэглээний төлбөр, татвар даатгал, торгууль төлөх боломжийг бий болгохоор холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

САЛБАР НЭГЖҮҮД

Манай бүх салбар, тооцооны төвүүд нь дээд зэргийн тав тух, аюулгүй байдлыг эрхэм болгон үйлчлэх үүднээс шаардлагатай бүхий л тоног төхөөрөмжийг орчин үеийн загвар хийц бүрдүүлэн ажиллаж байна. Бид салбар, тооцооны төвүүд, оффисуудаа дулаан, тайван, зочломтгой уур амьсгалтай байлгах зорилгоор хамгийн тайван өнгө болох нил ягаан өнгөөр голлон тохижуулсан. Манай салбар, тооцооны төвүүдээр өөрийн бизнес, ажил хэргээ тэлэн, санхүүгийн шийдлээ олохоор зорин ирсэн үйлчлүүлэгч бүрт ажиллагсад маань тусгайлан анхаарч үйлчлэхээс гадна цай, кофены булангаас хүссэнээрээ үйлчлүүлэх боломжтой байдаг билээ.

2020 оны 12 сарын 31-ны байдлаар Ариг Банк нь нийт 45,000 харилцагчиддаа Улаанбаатар болон Дархан хотуудад байрших нийт 11 салбар нэгжээр дамжуулан үйлчилсэн байна.

САЛБАР НЭГЖИЙН МЭДЭЭЛЭЛ

	3 үгт хаяг
Хан-Уул	///////явах.найдлага.малтмал
Сонгинохайрхан	//////тэмүүлэл.онцлог.нүхлэх
Баянзүрх	//////аялдаг.дайчлах.жишээлэх
Хан-Уул Юнайтэд	//////давхцал.үйлдэх.найрамдал
Хороолол	//////ариусах.өгүүлбэр.айзам
40Мянгат	//////далан.сүлжээ.улиас
М20	//////уянгалаг.жишээлэх.тансаг
Бөмбөгөр	//////сондгой.түшиг.аргачлал
Дархан	//////баясав.зууван.хэрэглээг
Дархан Олон улс	//////алаглах.удэлт.цонх
Дархан Зах	//////нуур.тогоо.тогос

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

1997

“Эрэлбанк” нэртэйгээр үйл ажиллагаа явуулах эрхээ авснаар “Эрэлбанк”-ны түүхийн хуудас бичигдэж эхэлжээ.

2009

Харилцагчийн үйлчилгээг сайжруулах зорилгоор уламжлалт шилэн хаалт, решёткаг халсан анхны банк болсон.

2013

Монголд анх удаа гар утсаараа төлбөрийн карт уншигч төхөөрөмжийг нэвтрүүллээ.

Эрэлбанкны гар утасны аппликейшн болох ПокетБанкийг зах зээлд нэвтрүүллээ.

“ПРЕСТИЖБАНКИНГ” нэрээр банкны үйлчилгээний дээд стандартаар ажиллах онцгой салбараа нээлээ.

2014

Банк дүр төрхийг шинэчилж Ребрэндинг АРИГ БАНК боллоо.

Төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулж бүх харилцагчдын өргөөдөд ТҮЦ машиныг байршууллаа.

“Хог цэвэрлэсэнд баярлалаа” флашмобыг эхлүүлж олон нийтийг ил задгай хог хаяхгүй байхыг уриалсан аян өрнүүллээ.

Технологийн дэвшлийг банкны үйл ажиллагаандаа нэвтрүүллээ.

2015

Байгаль орчиндээлтэй үйл ажиллагааг таниулах үүднээс “НОГООН ОФФИС” ажлыг эхлүүллээ.

Монгол улсын арилжааны банкны салбарт анх удаа “Ариг Тур” буюу банкны “НОГООН ОФФИС”-ыг танилцуулдаг боллоо.

Achilles Mongolia ТББ-ыг үүсгэн байгуулж жил бүр “Итгэл Найдвар Боломж” марафоныг зохион байгуулж байна.

ING Bank болон НҮБ-ын “Хүүхдийн Сан”-тай хамтран “Гэр цэцэрлэг” хөтөлбөрийг жил бүр хэрэгжүүлж байна.

2017

“ТоС Манлайлагч байгууллага”-аар шалгарлаа.

“Шилдэг ТоС арга хэмжээ”-ээр шалгарлаа.

Ариг Банк хоёр хувь нийлүүлэгчтэй боллоо.

“Asia Money Country Awards”-аас “Нийгмийн хариуцлага хэрэгжүүлэгч шилдэг Банк”-аар шалгарлаа.

“Утааг хамтдаа устгая!” Инновацийн төслийг амжилттай зохион байгууллаа.

2018-2020

ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандарт.

ISO 10002 Чанарын менежмент-Харилцагчийн сэтгэл ханамжийн стандарт Австралийн BSC стандартчиллын компаниас Баталгаажуулалтын гэрчилгээ гардан авлаа.

Монголд анх удаа дүрэмт хувцсаа үндэсний хэв маяг агуулсан, хүний биед хор нөлөөгүй хоёрдогч түүхий эдээр боловсруулсан материалаар хийлээ.

Нидерландийн ING Bank болон НҮБ-ын “Хүүхдийн Сан”-тай хамтран уламжлал болгон зохион байгуулдаг “Гэр цэцэрлэг” хөтөлбөрийг дөрөвдэхь жилдээ хэрэгжүүлж Баянзүрх дүүргийн 251 дүгээр цэцэрлэгийн дэргэд хоёр гэр, нэг ариун цэврийн байгууламж бүхий өргөтгөлийг албан ёсоор хүлээлгэн өглөө.

ASIAMONEY сэтгүүлийн “Нийгмийн Хариуцлагын хэрэгжүүлэгч Шилдэг Банк” 2018, 2019

CFI.co (Capital Finance Investment) сэтгүүлийн “Шилдэг Ногоон Банк”, “Бизнест Ээлтэй Шилдэг Банк” 2018 шагналын болзлыг тус тус хангалаа.

Гадаад харилцаагаа өргөтгөн ОХУ-д байрших Ностро дансдын тоог нэмэгдүүллээ.

Төлбөрийн системийн шинэчлэл болон СТОУС-16 зэргийг нэвтрүүлэн санхүү бүртгэлийн үйл ажиллагааг тогтмол сайжруулан ажиллалаа.

Короновирусийн халдварын эсрэг ажлыг амжилттай зохион байгуулж дээрх хугацаанд дотооддоо эрсдэлгүй ажиллалаа.

БИДНИЙ ТҮНШҮҮД

АРИГ БАНК

arigbank.mn | 7013 3060 | arigbank